



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

*Монгол Улсын Ерөнхий прокурорын төсвийн
багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит*

Аудитын код: УАГ-САГ/2015/13/СТА-ТЕЗ

Улаанбаатар хот
2015 оны 4 дүгээр сар



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

YAG-ын Санхүүгийн аудитын газрын
дарга,
Тэргүүлэх аудитор С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: С.Оюунгэрэл
Утас: 260512
Цахим хаяг:
oyungerels@audit.gov.mn

Аудитор: П.Чанцалдулам
Утас: 261740
Цахим хаяг:
chantsaldulamp@audit.gov.mn

Монгол Улсын
Үндэсний аудитын газар
Улаанбаатар-15160
Бага тойруу 3
Засгийн газрын IV байр
Цахим хаяг: www.audit.mn

2015 оны 4 дүгээр сар

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
Байгууллагын хууль, эрх зүйн орчин
Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн
горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний
үр дүн
Дотоод хяналт
Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
Шилэн дансны мэдээлэл
Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн
талаар
Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх
тайлбар
Анхаарал татахуйц бусад чухал асуудал
Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн
нэгтгэл
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
Зөвлөмж
Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Улсын ерөнхий прокурорын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд (ҮАГ-САГ/2015/13/СТА-ТЕЗ) аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Улсын ерөнхий прокурорын төсвийн багцын 2014 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Улсын ерөнхий прокурорын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг 2015 оны 4 дүгээр сарын 20-наас 2015 оны 4 дүгээр сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын Нэгтгэсэн тайлангийн аудитын алба /НТАА/-ны аудитор П.Чанцалдулам хэрэгжүүлэв.

Улсын ерөнхий прокурорын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2015 оны 4 дүгээр сарын 3-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитыг 2015 оны 4 дүгээр сарын 20-наас 2015 оны 4 дүгээр сарын 24-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2014 оны 4 дүгээр сарын 25-нд Улсын ерөнхий прокурорын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Улсын ерөнхий прокурор болон харьяа прокурорын байгууллагууд нь Үндсэн хууль, Прокурорын байгууллагын тухай, Эрүүгийн тухай, Эрүүгийн байцаан шийтгэх тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Монгол Улсын төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал” -ыг ашиглаж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна.

Мөн Монгол Улсын Ерөнхий прокурорын тушаалаар баталсан дараах заавар, журмуудыг мөрдөж байна. Тухайлбал:

- Мөрдөн шалгах ажиллагаанд тавих хяналтын ажлын аргачилсан заавар” аргачлал
- “Ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналтын ажлын аргачилсан заавар”, “Аргачлал”
- “Прокурорын байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”,
- “Прокурорын байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийг хүлээн авч хянан шийдвэрлэх заавар”
- “Монгол Улсын прокурорын байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”
- “Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх зөвлөлийн ажиллах журам”
- “Прокурорын байгууллагын албан хэрэг хөтлөлт, баримт бичгийг архивт шилжүүлэх, хүлээн авах, хадгалах, ашиглуулах, тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэх журам”
- “Прокурорын байгууллагын санхүүд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”
- “Эрүүгийн хэргийн төв болон салбар архивт баримт хүлээн авах, тоо бүртгэл хөтлөх, баримтын хадгалалт, хамгаалалт, ашиглалтын журам”
- Баримт ашиглуулах үйл ажиллагаанд мөрдөх төлбөрт үйлчилгээний үнийн тариф”

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Прокурорын байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн чиг үүрэг бүхий, үйл ажиллагаагаа төрийн нэрийн өмнөөс явуулдаг, бие даасан, хараат бус, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага болно.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хvний эрхийг баталгаатай хангах явдлыг vйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэвшvлэх, шударга ёс, тэгш байдлыг хангах, прокурорын ёс зvйг чандлан сахиж, мэргэжлийн өндөр ур чадвар, хууль дээдлэх зарчимд тvшиглэсэн хууль сахиулах шударга тогтолцоог бий болгох явдал нь Прокурорын байгууллагын эн тэргvний зорилт юм.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Дараах албан тушаалтан төсвийн ерөнхийлөн захирагч байна” мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.12-т “Улсын ерөнхий прокурор прокурорын байгууллагын төсвийн” гэж заасны дагуу Улсын ерөнхий прокурор нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна”, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д “Төсвийн ерөнхийлөн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 4 дүгээр сарын 05-ны дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлж, аудит хийсэн

тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж заасныг тус тус баримтлан тайлагнасан байна.

Тухайн байгууллагын төсвийн 2014 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгож байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Улсын ерөнхий прокурорын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 12-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Аудитын нарийвчилсан горим, сорилыг хэрэгжүүлэх явцад гарсан зарим онцлог ажил гүйлгээнээс дурьдвал дараах байдалтай байна.

2014 оны Засгийн газрын 22 дугаар тогтоолын дагуу Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба нь Авилгатай тэмцэх газарт шилжсэнтэй холбогдуулан Улсын ерөнхий прокурорын цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд дараах өөрчлөлтүүд гарсан байна.

- Засгийн газрын оруулсан хөрөнгө 340.6 сая төгрөгөөр буурсан байна.
- Өмнөх үеийн үр дүнд -96.2 сая төгрөгийн өөрчлөлт орсон байна.
- Үндсэн хөрөнгийн данснаас 324.4 сая төгрөгийн анхны өртөгтэй 80.0 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгийг хассан байна.

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаандаа баримталдаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Сангийн яамнаас гаргасан НББ-ийн бодлого, заавар, журамтай нийцүүлэн боловсруулж 2011 оны 35 дугаар тушаалын 5 дугаар хавсралт эрх зүйн актаар баталгаажуулан мөрдөж байгаа ба тайлант онд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргасан байна.

Материаллаг байдлыг тодорхойлох

Төсвөөс санхүүждэг төрийн өмчит байгууллага тул төлөвлөлтөөр материаллаг байдлын суурийг төсвийн гүйцэтгэлийн зардлаар авч, түүний 2 хувиар тооцож, $19,340.6 \times 2\% = 386.8$ сая төгрөгөөр материаллаг байдлыг тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг тооцсон үзүүлэлтэд өөрчлөлт ороогүй бөгөөд ТЕЗ-ын аудитын явцад санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийгдсэнтэй холбоотойгоор төсвийн гүйцэтгэлийн зардлаар тооцсон материаллаг байдлын суурь $17,994.3 \times 2\% = 359.9$ сая төгрөг болж төлөвлөлтийн үе шатанд тооцсон материаллаг байдлын түвшинд 26.9 сая төгрөгөөр өөрчлөлт орсон болно.

Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна. Дотоод хяналт шалгалтын хэлтэс нь 2014 онд хийх шалгалтын жилийн төлөвлөгөөг Улсын Ерөнхий прокуророор батлуулан төлөвлөгөө хуваарийн дагуу мөрдөж ажилласан байна. Тайлант онд уг хэлтсээс ТЕЗ-ийн багцад харьяалагдах нийт 30 нэгж байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, 13 нэгж байгууллагаас нийт 2.2 сая төгрөгийн мөнгөн алдаа зөрчлийг илрүүлж ажиллажээ. Байгууллагуудад гарсан алдаа зөрчлийг тухай бүрд нь залруулж, давтан гаргахгүй байх талаар анхаарч, системийн хэмжээнд нийтлэг гарсан зөрчлийг нэгтгэн, цаашид авч хэрэгжүүлэх 6 зөвлөмжийг өгч ажилласан байна. Мөн Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар, Хууль, Худалдан авах ажиллагааны бодлогын газруудтай хамтран УЕПГ-ын 2014 оны худалдан авах ажиллагаанд дотоод аудит хийснээр худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих журмыг мөрдлөг болгон ажилласан байна гэж дүгнэжээ. Гэвч дотоод аудитын дүрмийн 2 дугаар зүйлийн 2.1 мөн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.1-т "Дотоод аудитын нэгж нь Төрийн аудитын байгууллагатай дараах хүрээнд хамтран ажиллаж болно 9.1.1-9.1.3 дахь заалт" гэснийг тус тус баримтлан төсвийн шууд захирагчдын 2014 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтээр гарсан доорх асуудлуудад анхаарал хандуулан гарсан алдаа зөрчлийг дахин гаргахгүй байх, аудитын зөвлөмжийн хэрэгжилт биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг зөвлөж байна.

Төсвийн шууд захирагч нарын 2014 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын талаар

Аудитаар нийт 1,077.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсний 5.0 сая төгрөгийн зөрчилд 7 акт тавигдсан, 23.8 сая төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага бичигдсэн, 175.0 сая төгрөгийн зөрчилд 61 зөвлөмж өгөгдсөн, 873.5 сая төгрөгийн 31 алдаанд залруулга хийгдсэн байна. Аудитаар илэрсэн бүх асуудлыг тус байгууллагын удирдлага болон дотоод аудитын нэгж авч үзэж, судлан шийдвэрлэх шаардлагатай ба аудитын явцад илрүүлсэн алдааг үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрч, залруулга хийгдсэн байна.

2014 оны санхүүгийн тайлангийн аудитаар ТШЗ-ийн хэмжээнд хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Нэг. Орон нутаг дахь харьяа байгууллагуудад хийсэн аудитаар илэрсэн зарим асуудлуудын талаар

1. Төсвийн хөрөнгийн зарцуулалт, түүнд тавих хяналтын талаар

- Замын Үүд болон Говь-Алтай аймгийн прокурорын газруудад хийсэн 2014 оны санхүүгийн тайлангийн аудитаар цалингийн зардлаас нийт 1.8 сая төгрөгийг томилолт болон ажлын хөлсөнд зарцуулсан зөрчил илэрсэн байна.
- Завхан, Булган аймгуудын прокурорын газар мөн Сэлэнгэ аймгийн Мандал болон Сайхан сумдын прокурорын газрууд нийт 11.0 сая төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн шилжүүлж зарцуулсан байна. Үүнээс 4.1 сая төгрөгийг нь дээд шатны байгууллагын зөвшөөрөлгүйгээр зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулжээ. Эдгээр нь Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалтай нийцэхгүй байна.
- Сүхбаатар аймгийн прокурорын газар нь батлагдсан орон тооноос гадуур малчин цалинжуулж 2.7 сая төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэж заасантай нийцэхгүй байна.
- Дундговь аймгийн прокурорын газар нь тайлант онд 6.0 сая төгрөгийн төсвийн үлдэгдлээс 4.0 сая төгрөгийг Улсын ерөнхий прокурорын ахмадын санд, 2.0 сая төгрөгийг өөрийн байгууллагын ахмадын сангийн дансанд тус тус шилжүүлсэн байна.

2. Санхүүгийн тайлагналын талаар

- Говьсүмбэр аймгийн прокурорын газар нь цалингийн журналын бичилтийг холбогдох анхан шатны баримттай тулган шалгаж үзэхэд цалингийн урьдчилгаа дансанд 5.6 сая төгрөгийг бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т “Санхүүгийн тайлан нь үнэн зөв, баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх” гэсэнтэй нийцэхгүй байна.
- Батлагдсан төсвийг зүй зохистой удирдаагүйгээс 2.2 сая төгрөгийн өр төлбөр, 2.5 сая төгрөгийн авлага үүсгээд бүртгэлд тусгаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 болон НББ-ийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 болон 9 дүгээр зүйлийн 9.1-ийн заалттай нийцэхгүй байна.
- Завхан аймгийн прокурорын газар нь анхан шатны баримтыг үндэслэлгүйгээр 1.2 сая төгрөгийн зардлыг буруу бүртгэсэн, 0.9 сая төгрөгийн орлогыг бууруулах бичилт хийсэн зэрэг нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Аж ахуй нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө” мөн Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан журам, аргачлалтай тус бүр нийцэхгүй байна.

Хоёр. Нийслэлийн прокурорын харьяа байгууллагуудад хийсэн аудитаар илэрсэн зарим асуудлуудын талаар

1. Бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл, ангидал, худалдан авалтын талаар

- Нийслэлийн прокурорын газар нь худалдан авсан 1.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн байна Энэ нь Сангийн сайдын 2008 оны “Тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 352 дугаар тушаал, Сангийн сайдын 388 дугаар тушаалын холбогдох заалттай нийцэхгүй байна.
- Дүүргийн нэгдүгээр прокурорын газар нь худалдан авсан 1.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 9.9 сая төгрөгийн бараа материалыг тооцооны болон хөрөнгийн дансаар дамжуулалгүй шууд зардалд бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.21, 2008 оны “Тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 352 дугаар тушаалын 1.6 заалттай тус бүр нийцэхгүй байна.
- Дүүргийн хоёрдугаар прокурорын газар нь бараа материалын дансанд 11.7 сая төгрөгийн хөрөнгийг нэр төрөл, тоо ширхэгээр бүртгэж тайлагнаагүй, 3.7 сая төгрөгийн

хөрөнгийг буруу ангилан бүртгэсэн, бараа материалын дансаар дамжуулалгүй 4.4 сая төгрөгийн материалыг шууд зардалд бүртгэсэн зэрэг нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан НББ-ийн дансны заавар болон уг зааврын 4.16-д “Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг мөрдөнө” гэсэнтэй нийцэхгүй байна.

- Дүүргийн хоёрдугаар прокурорын газар нь ашиглаж байгаа 1.5 сая төгрөгийн хангамжийн материалыг шууд зарлагадсан нь НББ-ийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т “санхүүгийн тайлан нь үнэн зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх” гэсэнтэй нийцэхгүй байна.

2. Санхүүгийн тайлагнал болон хууль эрх зүйн асуудал

- Нийслэлийн прокурорын газар нь арилжааны банкинд байршуулсан иргэдийн батлан даалтын барьцаа 53.0 сая төгрөгийг өглөгөөр тусгаагүй нь НББ-ийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-т “Аж ахуй нэгж байгууллага нь өр төлбөрөө НББОУС-ын дагуу үнэлж дансанд тусгана” гэсэнтэй нийцэхгүй байна.
- Дүүргийн нэгдүгээр прокурорын газар нь зохих шалгуур үзүүлэлтээр дүгнэхгүйгээр тушаал гарган ур чадварын нэмэгдлийг ТҮ ангиллаар цалинждаг нийт 22 хүнд сар бүр тогтмол 25 хувиар тооцон олгосон нь Хүн амын бодлого, Хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны хамтарсан 63/104 тушаалын 2. “,,,дараах үндсэн шалгуур үзүүлэлтийг харгалзан”, 5. “,,,улирал бүр хэлэлцэн шийдвэрлэж байна”, 7. “,,,ажилтнуудын цалинг нэмэх, амьдрал ахуйг харгалзах зэргээр хавтгайруулан олгохыг хориглоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.
- Дүүргийн гуравдугаар прокурорын газар нь 1 өрөө орон сууц худалдан авахдаа тендерийн бичиг баримт боловсруулаагүй, сонгон шалгаруулалт зарласан баримт, ирүүлсэн санал, үнэлгээний хуудас зэрэг баримт материалууд байхгүй, үнэлгээний хорооны шийдвэр гарахаас өмнө орон сууц худалдан авах гэрээг байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай /ТБОНАХБАҮХАТухай/ хуультай нийцэхгүй байна.

ТШЗ-ийн хэмжээнд илэрсэн дээрх асуудлууд нь 2013 оны ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд мөн адил хөндөгдсөн ба тайлант онд давтан гарсан тул аудитаар илэрсэн бүх асуудлыг тус байгууллагын удирдлага болон дотоод аудитын хэлтэс авч үзэж, судлан шийдвэрлэх шаардлагатай байгааг Улсын Ерөнхий прокурорын удирдлагын анхааралд хандуулж байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2014 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу сангийн яамны Төрийн сангийн харилцах 900006001, 900006300, 900006002 тоот дансдаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулан төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангаж, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2014 оны төсвийн тухай хуулиар 19,347.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 17,994.3 сая төгрөгийг зарцуулж, 15.3 хувь буюу 1,353.1 сая төгрөгийг хэмнэсэн байна. Төсөв хэмнэсэн гол шалтгаан нь 2014 оны сүүлийн хагас жилд МУ-ын төсвийн орлого тасарснаас зардлын эрхийг Сангийн яамнаас хязгаарласантай холбоотой байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогын талаар: Тайлант онд Улсын ерөнхий прокурорын газар нь оюутны дадлагын төлбөрөөс 2.4 сая, туслах аж ахуйгаас 1.7 сая, Сургалт

судалгааны төвийн танхимын түрээсийн орлого 21.2 сая, нийт 25.3 сая төгрөгийн орлого олж, улсын төсөвт нийт 2.4 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Хөрөнгө оруулалтын зардалд 2,159.0 сая төгрөг батлагдсанаас 2,152.2 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон ба зарцуулагдаагүй үлдэгдэл 6.8 сая төгрөг байна.

Хөрөнгө оруулалтад олгогдсон санхүүжилтийн 26.8 хувь буюу 577.7 сая төгрөгийг машин, тоног төхөөрөмж, 73.2 хувь буюу 1,574.5 сая төгрөгийг барилга байгууламжид зарцуулсан байна.

Шилэн дансны мэдээлэл

Прокурорын байгууллага нь улсын өмч хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагааны ил тод, нээлттэй ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхэд анхаарч “Шилэн дансны тухай хууль”-ийг 2015 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудас болон байгууллагын цахим хуудаст мэдээлэл оруулсан байдал нь дараах байдалтай байна. Үүнд:

- Төсөв ба гүйцэтгэл: Тус хэсэгт аймаг, нийслэл, дүүрэг, сум дунд, тээврийн прокурор, эрүүгийн хэргийн нэгдсэн төв архивын газрууд нь сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг өссөн дүнгээр оруулсан байна. Мөн түүнчлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийн мэдээллийг нэгтгэн оруулсан ба 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5-н зарлагын мөнгөн гүйлгээ /дүүргийн 1-р прокурорын ХАОАТ-ын 9.7 сая, НДШ-ийн 20.5 сая, тамгын газрын 3 дугаар сарын ХХОАТ-ын 10.3 сая, НДШ-ийн 25.4 сая, англи улсын төлөөлөгчийн онгоцны тийзний үнэ 9.0 сая/ нийт 74.9 сая төгрөгийн гүйлгээг мэдээлжээ.
- Хөрөнгө оруулалт: Хөрөнгө оруулалтын 2015 оны нэгдсэн төлөвлөгөөг оруулсан байна.
- Тендер, худалдан авалт: Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт хэсэгт Баян өлгий аймгийн прокурорын конторын барилгын гүйцэтгэлийн 351.4 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн мэдээллийг оруулсан байна.
- Үнэт цаас: Мэдээлэл байхгүй.
- Байгууллагын мэдээлэл: 2015 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, автомашин шилжүүлсэн тухай ТӨХ-ны 10-р тогтоол, Ерөнхий прокурорын тушаал, хөрөнгө актлах тухай ТӨХ-ний 44-р тогтоол, хөрөнгө шилжүүлэх тухай ТӨХ-ны 43-р тогтоолуудыг оруулжээ.

Байгууллагын бүх нэгж прокурорын газрууд www.shilendans.gov.mn-тэй холбогдсон бөгөөд үүнээс улсын ерөнхий прокурорын газар, нийслэл, дүүргийн 1, 4-р прокурорын газар, Өмнөговь, Ховд, Увс, Дорноговь, Хөвсгөл аймгийн прокурорын газар, Өмнөговь аймгийн Ханбогд сумын сум дундын прокурорын газар нийт 10 газар www.prokuror.mn-ийн “шилэн данс”-ны мэдээллийн хэсэгт нэгтгэн мэдээллээ оруулсан байна. Төсвийн төлөвлөгөө гүйцэтгэлийн талаарх шилэн дансны мэдээллийг Сангийн яаманд сар бүр тайлагнаж байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 16 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 11 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар

Тус байгууллагын төсвийн 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний засгийн газрын оруулсан капитал, урьдчилж орсон орлого зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/ Тухайлбал:

Тайлант онд өмчийн өөрчлөлтийн тайланд нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр 1,473.5 сая төгрөгийн ажил гүйлгээг залруулсан байна.

- УИХ-ын 2014 оны 22 дугаар тогтоолоор УЕП-ын дэргэдэх мөрдөн байцаах алба татан буугдаж, Авилгатай тэмцэх газарт нэгдсэнтэй холбогдуулан 96.2 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл хасагдсан байна.
- Дүүргийн 1 болон 2 дугаар прокурорын газар шинээр байгуулагдаж, 6 дүүргийн прокурорын газар татан буугдсантай холбоотой 219.7 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл хасагдсан байна.
- ТӨХ-ны тогтоолын дагуу зарим аймгийн прокурорын газрууд үндсэн хөрөнгөд бүртгэлтэй зарим эд хогшлыг актлан данснаас хассантай холбоотой нийт 33.9 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл хасагдсан байна.
- Өмнөх онд хөрөнгө оруулалтаар худалдан авсан хөрөнгүүдийг өөрийн харьяа холбогдох байгууллагуудад данснаас данс хооронд шилжүүлснээс 1,511.9 сая төгрөгийн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөд тусгасан байна.

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт хуримтлагдсан үр дүн дансны 26.9 хувийг эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Тайлант оны эцэст мөнгөн хөрөнгийн данс 1,243.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба үүнээс 7.6 сая төгрөгийн барьцаа хөрөнгийн мөнгөний үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна.

ТЕЗ-ийн аудитын явцад мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тулган баталгаажуулахад Нийслэлийн прокурорын газрын 2014 оны аудитлагдсан тайлан дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 53.0 сая төгрөг байхад дансны хуулгын баталгаагаар 32.0 сая төгрөгөөр нотлогдож, нийт 21.0 сая төгрөгөөр аудитлагдсан тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл зөрсөн болно. Дээрх мөнгөн хөрөнгийн зөрүүг давтан тооцоолж, санхүүгийн тайлангаас анхан шатны баримт руу хөөн шалгахад арилжааны банк дахь 2617000528, 2617000530, 2617000529 тоот дансдад 2014 оны 10 дугаар сарын 27-ны өдрөөс хойш орсон гарсан бүх ажил гүйлгээг тусгаагүй орхигдуулсныг илрүүлж, аудитын явцад санхүүгийн байдлын тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 21.0 сая төгрөгөөр буурч, мөнгөн гүйлгээний тайлангийн төлбөр хураамж бусад зардал 21.0 сая төгрөгөөр нэмэгдэж тайлагнагдсан болно.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-т "Эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай

тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах", 7 дугаар зүйлийн 7.1-т: "анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийн Иж бүрэн байх-д: "аж ахуй нэгж байгууллага тайлант хугацаанд гарсан бүх ажил гүйлгээ, үлдэгдэл буюу үйл явдал, нөхцөл байдлуудаас бүртгээгүй, нэмж тодруулаагүй, орхигдуулсан зүйлсгүй байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-т "эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах", 7 дугаар зүйлийн 7.1-т: "анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийн Иж бүрэн байх-д: "аж ахуй нэгж байгууллага тайлант хугацаанд гарсан бүх ажил гүйлгээ, үлдэгдэл буюу үйл явдал, нөхцөл байдлуудаас бүртгээгүй, нэмж тодруулаагүй, орхигдуулсан зүйлсгүй байх" гэснийг баримтлан тайлант хугацаанд орсон, гарсан бүх ажил гүйлгээг бүртгэлд үнэн зөв тусгаж, бүрэн хамруулах, бэлэн мөнгөний үлдэгдлийг жил, улирал, сарын эцэст тооллого хийж, баталгаажуулж байх талаар аудитын зөвлөмж өгөх;

2. Улсын ерөнхий прокурорын газар нь Сургалт судалгааны төвийн танхимын түрээсийн орлогоор тайлант онд нийт 21.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4-т "Туслах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг төсвийн жилийн дундуур авсан бол түүний төсвийг нэмэлт төсөв хэлбэрээр, бусад тохиолдолд тухайн жилийн төсөвт тусган хэрэгжүүлнэ" гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4-т "Туслах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг төсвийн жилийн дундуур авсан бол түүний төсвийг нэмэлт төсөв хэлбэрээр, бусад тохиолдолд тухайн жилийн төсөвт тусган хэрэгжүүлнэ" мөн хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.5, 47.3 дахь заалтыг үндэслэн сургалтын төвөөс олсон орлогыг төлөвлөж, батлагдсан төсвийг холбогдох арга хэмжээнд зарцуулах талаар зөвлөмж өгөх;

3. 2014 оны жилийн эцэст өглөгийн данс 1,480.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба нийт өглөгийн 99.9 хувь буюу 1,479.6 сая төгрөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулан санхүүгийн тайланд тайлагнасан байна. Нийт өглөгийн үлдэгдлийн 83.5 хувь буюу 1,237.0 сая төгрөг нь хувь хүмүүст төлөх өглөг ба үүний 1,226.8 сая төгрөг нь барьцаа хөрөнгийн үлдэгдэл байна. Тайлант онд өр төлбөр өмнөх оноос 640.9 сая төгрөгөөр өсчээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д: "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д: "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэснийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөх;

4. ТЕЗ-ийн аудитын явцад авсан судалгаагаар 2014 онд УЕП-ын Тамгын газрын харилцах данснаас нийт 178.5 сая төгрөгийг гадаад томилолтын зардалд зарцуулжээ. Нийт гарсан томилолтын зардлыг холбогдох анхан шатны баримттай нь тулган шалгахад кредит картны хуулгын дүнгээр нийт 8.0 сая төгрөгийг анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсныг жилийн эцэст томилолтын урьдчилгаа дансаар авлага үүсгэн бүртгэсэн байна.

2014 онд УЕП-ын Тамгын газрын харилцах болон кассын данснаас нийт 32.2 сая төгрөгийг бэлэг дурсгалын зардалд зарцуулсан ба үүний 17.4 сая төгрөгийг нормын хувцас, зөөлөн эдлэл авах зардлын ангиллаас бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна.

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд түүврээр хамрагдсан 3-н байгууллагын хувьд хүүхдийн баяр болон шинэ жилээр ажиллагсдын хүүхдүүдэд 40,000-50,000 төгрөгийн үнэтэй бэлэг өгч, тайлант онд нийтдээ 9.0 сая төгрөгийг зарцуулжээ.

Мөн тайлант онд Тамгын газрын кассаас 0.5 сая төгрөгийг гадаад томилолтын илүү ачаа тээшний зардалд төлжээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т: “анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаал, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т: “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” “Хэмнэлтийн горимд шилжих тухай” Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолын 5, 7, 8 дугаар заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны хүчин төгөлдөр баримтаар ажил гүйлгээг бүртгэлд тусгаж, тайлант хугацаанд үүсгэсэн томилолтын зардлыг илтгэх хуудаст үндэслэн дараа тайлангийн журмын дагуу ажлын 3 хоногт багтаан хааж, бүртгэж тайлагнах ба “Хэмнэлтийн горимд шилжих тухай” Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоол, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т: “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэснийг тус тус мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөх;

5. Төсвийн шууд захирагчдын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн хараат бус аудитын дүгнэлтээр прокурорын байгууллагын хэмжээнд нийтлэг дараах зөрчлүүд илэрчээ. Үүнд:
 - Батлагдсан төсөвт зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан;
 - Бараа материалыг шууд зардалд бүртгэсэн;
 - Бараа материал, үндсэн хөрөнгийг буруу ангилан бүртгэсэн;
 - Анхан шатны баримтын бүрдэл дугуу
 - Нягтлан бодох бүртгэлийн бичилтийг буруу хийсэн болон санхүүгийн тайлагналтай холбоотой гарсан зөрчлүүдэд Улсын Ерөнхий прокурорын удирдлага болон дотоод хяналт, шалгалтын хэлтэс нь анхаарал хандуулан тайлант онд гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, мөн хараат бус аудиторын өгсөн зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж хамтран ажиллах шаардлагатай байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод аудитын дүрмийн 2 дугаар зүйлийн 2.1-т “Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино”, мөн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.1-т “Дотоод аудитын нэгж нь Төрийн аудитын байгууллагатай дараах хүрээнд хамтран ажиллаж болно 9.1.1-9.1.3 дахь заалт” гэснийг тус тус мөрдөж, дотоод хяналт, шалгалтын хэлтсийн ажлын шалгалтын үр дүнг сайжруулах талаар зөвлөмж өгөх;

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитын явцад тухайн дансдын хувьд үүссэн материаллаг бус 711.7 сая төгрөгийн алдааг залруулах боломжгүй байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Улсын ерөнхий прокурорын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй ба эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Улсын ерөнхий прокурорын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 732.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 711.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 21.0 сая төгрөгийн алдааг залруулсан болно.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн захирагчийн төсвийн 2013 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар 4 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, биелэлт нь 75 хувьтай байна.

Зөвлөмж

Улсын ерөнхий прокурорын төсвийн багцын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар 5 зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн болно.

Зөрчилгүй санал дүгнэлт

Бид Улсын ерөнхий прокурорын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна гэж үзэж, “Зөрчилгүй” санал дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий аудитор санал болгож байна.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1

Мөнгөн хөрөнгө

Асуудал 2

Мөнгөн хөрөнгө

Асуудал 3

Өр төлбөр

Асуудал 4

Төсөвт зардал

Асуудал 5

Дотоод хяналтын талаар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг бэлтгэдэг бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ҮАГ-ын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь Улсын ерөнхий прокурорын төсвийн багцын нягтлан бодох бүртгэлийн бодлого, тогтолцоо, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний ойлголтыг тусгаж байгаа болно.

Үндэсний аудитын газар энэхүү зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

